**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДГА-2025/12/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг

2025 он


Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Ахлах аудитор: О.Нарангарав

Цахим хаяг: narangarav.o@audit.gov.mn

Аудитор: Н.Мөнхнасан

Цахим хаяг: munkhnasann.@audit.gov.mn


---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn
2025.03.25 № 1-6/337
танай ____________-ны №____________-т

ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ ДАРГА
И.БАТСҮРЭН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тус төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагч, сан, тусгай дансны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 70.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон материаллаг байдлын түүшингээс давсан байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Сумын татварын болон татварын бус орлогыг 1,151.3 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 1,355.9 сая төгрөгөөр биелэн 204.6 сая төгрөгөөр давсан байна. Орон нутгийн төсвөөс санхүүжих татаас санхүүжилтийн дүнг давсан орлогоор бууруулан олгосон байна.

**Аудитын гол асуудал**

1.Тайлант онд сумын ОНХС-ын хөрөнгөөр хийгдсэн 51.0 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээг данс бүртгэлд тусгаагүй орхигдуулсан байна. Мөн 19.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээний ажил гүйцэтгэх гэрээний хугацаа дууссан байхад гэрээг дүгнэж ажлыг дуусгавар болгон хүлээн авч данс бүртгэлд тусгасан эсэхийг нотлох баримт бүрдэл хангалтгүй байна.

442502018

2. Тооцоолсон цалин хөлснөөс суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийг шилжүүлэхдээ үндсэн цалин болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна. Засаг даргын Тамгын газар 0.5 сая төгрөгийг, Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 0.1 сая төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд сумын түүхт 100 жилийн ой болсонтой холбогдуулан төсвийн харилцах дансаар дамжуулан хандив төвлөрүүлээгүй байна. Нутгийн зөвлөлөөс 32.4 сая төгрөгийн, сумын үе үеийн төгсөгчид анги хамт олноос 32.9 сая төгрөгийн нийт 65.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч ЗДТГ-ын данс бүртгэлд тусгаж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээлэл хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

**/мянган төгрөг/**

| Код | Тайлангийн үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **606,432.70** | **709,675.10** |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 121,798.00 | 228,288.30 |
| 33 | АВЛАГА | 229,025.00 | 169,008.30 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 192,943.20 | 208,127.00 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 62,666.50 | 104,251.50 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,687,541.00** | **2,642,648.40** |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,687,541.00 | 2,642,648.40 |
| 39200 | Биет хөрөнгө | 2,598,480.90 | 2,552,547.00 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 89,060.00 | 90,101.40 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,293,973.60** | **3,352,323.50** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **153.2** | **16,718.20** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **153.2** | **16,718.20** |
| 41300 | Өглөг | 153.2 | 16,718.20 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,293,820.40** | **3,335,605.20** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **3,293,820.40** | **3,335,605.20** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 531,493.00 | 531,493.00 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 2,537,319.30 | 2,584,910.00 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 225,008.20 | 219,202.20 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,293,973.60** | **3,352,323.50** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

**/мянган төгрөг/**

| Код | Тайлангийн үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | 2,851,871.00 | 2,519,782.80 |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | 1,034,299.00 | 1,345,110.80 |
| 110 | Орлогын албан татвар | 831,537.90 | 1,202,868.30 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 831,537.90 | 1,202,868.30 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 73,773.80 | 17,676.10 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 128,987.30 | 124,566.40 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 817,220.50 | 189,405.10 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 817,220.50 | 189,405.10 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 1,000,351.40 | 985,266.90 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | 2,185,163.40 | 2,475,329.90 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,185,163.40** | **2,475,329.90** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,080,121.90** | **2,464,842.90** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 595,348.80 | 941,435.10 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 66,110.10 | 112,524.70 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 68,488.00 | 321,528.40 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 632,611.60 | 562,677.60 |
| 2105 | Нормативт зардал | 823.5 | 0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 17,166.60 | 37,115.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 7,040.50 | 7,866.10 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 93,838.80 | 242,089.50 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 598,694.10 | 239,606.60 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 105,041.50 | 10,487.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **666,707.50** | **44,452.90** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **134,991.80** | **941.3** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **531,715.70** | **43,511.60** |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **531,492,966.81** | **225,008,202.76** | **1,986,126,875.12** | **2,742,628,044.69** |
| **2** | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 19,476,689.31 | 19,476,689.31 |
| **3** | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 531,492,966.81 | 225,008,202.76 | 2,005,603,564.43 | 2,762,104,734.00 |
| **9** | Тайлант үеийн үр дүн | - | - | 531,715,697.09 | 531,715,697.09 |
| **10** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **531,492,966.81** | **225,008,202.76** | **2,537,319,261.52** | **3,293,820,431.09** |
| **11** | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **531,492,966.81** | **225,008,202.76** | **2,537,319,261.52** | **3,293,820,431.09** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 4,079,151.92 | 4,079,151.92 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **531,492,966.81** | **225,008,202.76** | **2,541,398,413.44** | **3,297,899,583.01** |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | -5,805,967.92 | - | -5,805,967.92 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | 43,511,604.60 | 43,511,604.60 |
| **20** | **2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **531,492,966.81** | **219,202,234.84** | **2,584,910,018.04** | **3,335,605,219.69** |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

**/мянган төгрөг/**

| Код | Тайлангийн үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,168,391.2** | **2,429,320.3** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **1,034,299.00** | **1,345,110.80** |
| 110 | Орлогын албан татвар | 831,537.90 | 1,202,868.30 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 831,537.90 | 1,202,868.30 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | **73,773.80** | **17,676.10** |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 128,987.30 | 124,566.40 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 31,476.50 | 31,206.20 |
| 1181 | Газрын төлбөр | 20,063.30 | 17,583.00 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 77,447.60 | 75,777.20 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **122,528.90** | **76,903.80** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 122,528.90 | 76,903.80 |

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 1,011,563.20 | 1,007,305.60 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,168,786.40** | **2,308,830.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,168,786.40** | **2,308,830.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,487,982.90** | **1,778,898.20** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 595,670.80 | 928,049.20 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 66,306.50 | 112,889.20 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 68,916.40 | 321,528.40 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 44,980.90 | 52,300.60 |
| 2105 | Нормативт зардал | 600 | 0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 17,499.00 | 39,243.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 7,040.50 | 7,866.10 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 164,130.80 | 300,769.30 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 522,838.00 | 16,252.40 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 680,803.50 | 529,931.80 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **-395.2** | **120,490.30** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **25,135.90** | **14,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 25,135.90 | 14,000.00 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 25,135.90 | 14,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-25,135.90** | **-14,000.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **-25,531.00** | **106,490.30** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 147,329.10 | 121,798.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 121,798.00 | 228,288.30 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/мянган төгрөг/**

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | ЗГСУМС | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,410,835.20** | **2,126,979.50** | **1,362,024.19** | **764,955.31** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,410,835.20** | **2,126,979.50** | **1,362,024.19** | **764,955.31** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,861,250.30** | **1,618,334.46** | **1,356,714.19** | **261,620.27** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **930,422.60** | **928,049.16** | **928,049.16** | **0.00** |
| 210101 | Үндсэн цалин | 434,436.00 | 427,731.51 | 427,731.51 | 0.00 |
| 210102 | Нэмэгдэл | 337,807.60 | 353,908.94 | 353,908.94 | 0.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 72,296.00 | 62,064.57 | 62,064.57 | 0.00 |
| 210104 | Урамшуулал | 62,123.00 | 64,384.15 | 64,384.15 | 0.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 23,760.00 | 19,960.00 | 19,960.00 | 0.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **115,337.90** | **112,889.24** | **112,889.24** | **0.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 78,209.60 | 76,660.94 | 76,660.94 | 0.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,282.10 | 9,057.10 | 9,057.10 | 0.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,425.70 | 7,245.70 | 7,245.70 | 0.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,856.40 | 1,811.40 | 1,811.40 | 0.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,564.10 | 18,114.10 | 18,114.10 | 0.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **403,069.90** | **321,528.35** | **74,477.90** | **247,050.45** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 45,966.50 | 42,948.88 | 42,948.88 | 0.00 |
| 210302 | Түлш, халаалт | 313,740.10 | 248,118.97 | 248,118.97 | 0.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 43,363.30 | 30,460.50 | 30,460.50 | 0.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 52,309.30 | 52,300.63 | 52,300.63 | 0.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,170.00 | 8,170.00 | 8,170.00 | 0.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 38,735.30 | 38,732.15 | 38,732.15 | 0.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,064.00 | 3,058.48 | 3,058.48 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **240.00** | **240.00** | **240.00** | **0.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,100.00 | 2,100.00 | 2,100.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **49,450.00** | **49,442.99** | **36,449.99** | **12,993.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,200.00 | 5,200.00 | 5,200.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 5,000.00 | 5,000.00 | 5,000.00 | 0.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 39,250.00 | 39,242.99 | 39,242.99 | 0.00 |
| 210807 | Газрын төлбөр | 8,214.70 | 7,866.10 | 7,866.10 | 0.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,214.70 | 7,866.10 | 7,866.10 | 0.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **289,963.10** | **133,775.69** | **132,198.87** | **1,576.82** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **288,092.10** | **132,758.36** | **131,181.54** | **1,576.82** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **961.00** | **543.15** | **543.15** | **0.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 472.00 | 298.37 | 298.37 | 0.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **238.00** | **121.00** | **121.00** | **0.00** |
| 310004 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 200.00 | 54.82 | 54.82 | 0.00 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **12,482.80** | **12,482.30** | **12,482.30** | **0.00** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,500.00 | 5,500.00 | 5,500.00 | 0.00 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,982.80 | 6,982.30 | 6,982.30 | 0.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **549,584.90** | **508,645.04** | **5,310.00** | **503,335.04** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 544,274.90 | 503,335.04 | 0.00 | 503,335.04 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 544,274.90 | 503,335.04 | 503,335.04 | 0.00 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 5,310.00 | 5,310.00 | 5,310.00 | 0.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/мянган төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **186,480.92** | **-186,480.92** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **186,480.92** | **-186,480.92** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **170,793.60** | **-170,793.60** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **170,793.60** | **-170,793.60** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 170,793.60 | -170,793.60 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **15,687.32** | **-15,687.32** |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **15,687.32** | **-15,687.32** |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 15,687.32 | -15,687.32 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **186,480.92** | **-186,480.92** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **186,480.92** | **-186,480.92** |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 121,925.00 | -121,925.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 64,555.92 | -64,555.92 |

## 2.7 Аудит хийсэн ахмадын сангийн гүйцэтгэлийн тайлан

**/мянган төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,600.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,600.0** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **5,600.0** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **5,600.0** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,600.0 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **3,916.5** |
| **12** | **Татварын бус орлого** | **3,916.5** |
| 120009 | Бусад орлого | 3,916.5 |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **11,493.9** |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **9,810.3** |

## *3.ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН САНХҮҮГИЙН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ*

### *3.1 Засаг даргын Тамгын газар*

Аудитаар нийт 52,225.1 мянган төгрөгийн 6 алдаа, 2 зөрчил илэрснээс 51,717.8 мянган төгрөгийн 4 алдааг аудитын явцад бүрэн залруулсан.

**Залруулсан алдаа**

1. Санхүүжилтийн эх үүсвэрийг төсвийн гүйцэтгэлийн тайланд бүртгэхдээ орон нутгийн төсвөөс 25,778.3 мянган төгрөг, нэмэлт дансанд дээд шатнаас олгосон 20,325.1 мянган төгрөгийн дэмжлэгийг орлогын ангиллын буруу илэрхийлсэн байна.

2. Санхүүгийн байдлын тайланд тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан зардлыг хөрөнгийн зардалд бүртгэхдээ 3,800.0 мянган төгрөгөөр, тайлант үеийн үр дүнг 827.4 мянган төгрөгөөр тус тус дутуу бүртгэсэн байна.

3. Тайлант онд үүссэн өглөг, авлагын тооцооллыг тулгахад нийгмийн даатгалын шимтгэлийг шилжүүлэхдээ 332.7 мянган төгрөгийг дутуу, татварын тайланд шилжүүлсэн суутгалыг 266.9 мянган төгрөгөө илүү, тайлагнасан байхад өглөг, авлагад бүртгээгүй байна.

4. Тооцоолсон цалингаас нийгмийн даатгалын шимтгэл болон гарт олгох дүнг өглөгийн дансаар дамжуулан зардалд бүртгэхдээ дансны харьцааг буруу үүсгэн цалингийн зардлаас 54.7 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 332.7 мянган төгрөгийг дутуу бүртгэж өглөг үүсгэн нягтлан бодох бүртгэлийг буруу хөтөлсөн байна.

**Албан шаардлага:**

1. Тайлант онд Нийгмийн даатгалын шимтгэлийг шилжүүлэхдээ ажил цалингийн зардлаас шилжүүлэх 507.2 мянган төгрөгийг ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас шилжүүлэн зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.

2.Тайлант онд 28,345.4 мянган төгрөгийн 2 орлогын гүйлгээ, 130,911.6 мянган төгрөгийн 13 зарлагын гүйлгээг хуулийн хугацаанд хоцроож, 137,499.6 мянган төгрөгийн шийдвэрийг байршуулаагүй байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байх, мэдээллийн ил тод байдал алдагдах эрсдэлтэй байна.

***3.2 Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал***

Аудитаар нийт 9,272.3 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрснээс 9,152.3 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад бүрэн залруулсан.

**Залруулсан алдаа:**

1. Санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 1,018.1 мянган төгрөгөөр дутуу орлого үр дүнгийн тайлангийн үндсэн хөрөнгийн тайлант оны элэгдлийн зардал 1,214.5 мянган төгрөгөөр дутуу төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө нь сангийн яамны төсвийн хэлбэлзлийн төлөвлөгөөнөөс 5,250.0 мянган төгрөгийн илүү байна.

2. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланг ерөнхий журналтай тулган баталгаажуулахад нэмэгдсэн хасагдсан хөрөнгийг НББ-т бүртгэхдээ 714.5 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн байна.

3. Өмнөх оны ажилчидтай холбоотой авлагын үлдэгдэл 782.1 мянган төгрөг, тайлант онд үүссэн 173.0 мянган төгрөгийн өглөгийг дутуу бүртгэсэн байна.

**Албан шаардлага:**

1. Тайлант онд цалингийн зардлаас 120.0 мянган төгрөгийг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлээс зориулалт бусаар зарцуулсан байна.

2. Шилэн дансны цахим системд 15.0 сая төгрөгийн 23 тушаалыг хугацаа хоцроож 3.5 сая төгрөгийн 2 тушаалыг байршуулаагүйд байгаа нь мэдээллийн ил тод байдлыг хангахгүй байх, өмнөх онд зөвлөмжөөр өгсөн алдаа зөрчлийг давтан гаргасан хуулийн хэрэгжилт хангалтгүй байх эрсдэлтэй байна.

***3.3 Орон нутгийн хөгжлийн сан***

Аудитаар нийт 210.0 сая төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс 140.0 сая төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 70.0 сая төгрөгийн 3 зөрчилд 2 албан шаардлага өгөв.

**Залруулсан алдаа:**

1.Төсвийн гүйцэтгэлийн тайланд сумын ИТХ-аар батлагдсан ОНХС-ийн төлөвлөгөө 544,274,900 төгрөгийг тусгаж тайлагнаагүй алдааг залруулсан.

2.Санхүү байдлын тайланд барилга дансны үлдэгдлийг 70,000,000 төгрөгөөр илүү, орлого үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгө , бараа материал худалдсаны гарзыг 70,000,000 төгрөгөөр дутуу, нийт 140,000,000 төгрөгийг зөрүүтэй тайлагнасан алдааг залруулсан.

**Албан шаардлага:**

1.Тайлант хугацаанд ашиглалтад хүлээн авсан 51,000,000 төгрөгийн 3-н төсөл арга хэмжээг ашиглагч байгууллагын данс бүртгэлд тусгаагүй байна.

2.Гэрээний хугацаа дууссан 19,000,000 төгрөгийн 1 төсөл арга хэмжээний санхүүжилтийг бүрэн олгосон байна. Хугацаа дууссан төсөл арга хэмжээг хүлээн авсан баримт бичиг, байхгүй тухайн хариуцагч байгууллага ажлыг бүрэн дуусгасан гэх нотлох баримт хангалтгүй байна.

3.Шилэн дансны системд байршуулбал зохих 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын 15 гүйлгээ байршуулахаас 8 гүйлгээг хугацаа хоцроож, 7 гүйлгээг байршуулаагүй, хөрөнгө зарцуулах 7-н тушаал шийдвэрээс хугацаанд нь шийдвэр байршуулж, 5 шийдвэрийг огт байршуулаагүй байна.

***3.4 Хоршоо хөгжүүлэх сан***

Аудитаар нийт 4,672.4 мянган төгрөгийн 2 алдаа, илэрснээс аудитын явцад бүрэн залруулсан.

**Залруулсан алдаа:**

1.Үндсэн зээлийн авлагын эхний үлдэгдлийг 225,135 дутуу зөрүүтэй тайлагнасан байна. Зээлийн хүүгийн авлага 965,290 төгрөгийг дутуу тооцоолсон байсныг залруулсан.

2.Тайлант оны үр дүн хүү алданги нь 1,808,269 төгрөг байхад 3,482,014 төгрөгөөр, илүү бүртгэсэн алдаа залруулсан.

## 4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сангийн нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 2 санхүүгийн тайлан дүгнэлт 3 санхүүгийн тайлан аудитын түүвэрт хамрагдсан байна.

Нөхөн сэргээлтийн тусгай дансны санхүүгийн тайланг аудит хийх байгууллагын тоонд оруулж, аудит хийх хуваарь батлуулаагүй ба ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн хугацаанд аудитад хамруулж, шалгасан болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 696.4 сая төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрсэн. Аудитын явцад 969.4 сая төгрөгийн 4 алдааг бүрэн залруулга хийсэн.

***Залруулга:***

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд нийт зардлын гүйцэтгэлээс ахмадын сангийн зарцуулалт 5,600,000 төгрөгөөр илүү бүртгэсэн байсныг залруулсан.
2. Мөнгөн гүйлгээний тайланд тогтмол зардал 247,050,452 төгрөг, эд хөгшил урсгал засварын зардал 23,200,010 төгрөг, дотоод томилолтын зардал 348,600 төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх бараа үйлчилгээ зардал 10,806,185 төгрөг,бараа үйлчилгээний бусад зардал 263,813,076төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулал зардал 5,600,000 төгрөгийг тус тус зөрүүтэй тусгасан байсныг залруулсан.
3. Орлого үр дүнгийн тайланд үйл ажиллагааны үр дүнг 70,000,000 төгрөгөөр илүү илэрхийлсэн байсныг залруулсан.
4. Санхүүгийн байдлын тайланд нийт хөрөнгийн дүнг 70,000,000 төгрөгөөр илүү бүртгэсэн байсныг заруулсан.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад
талархал илэрхийлье.

## 5.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаа гүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Засаг Даргын Тамгын Газар | 4 | 51,717.8 | 1 | 4,627.4 | 3 | 47,090.4 | 4 | 51,717.8 | | |
| Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 3 | 9,152.3 | 1 | 714.5 | 2 | 8,437.7 | 3 | 9,152.3 | | |
| Орон нутгийн хөгжлийн сан | 2 | 140,000.0 | - | - | 2 | 140,000.0 | 2 | 140,000.0 | | |
| Хоршоо хөгжүүлэх сан | 2 | 4,672.4 | - | - | 2 | 4,672.4 | 2 | 4,672.4 | | |
| ТТЗ | 4 | 696,418.3 | - | - | 4 | 696,418.3 | 4 | 696,418.3 | | |
| **Дүн** | **15** | **901,960.8** | **2** | **5.341.9** | **13** | **896,618.8** | **15** | **901,960.8** | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөм ж | | Хариуцлаг а А/ш | | Хууль хяналтын байгууллага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | | Тоо | Дүн |
| Засаг Даргын Тамгын Газар | 1 | 507.3 | - | - | 1 | 507.3 | - | - | - | - | - | - |
| Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 1 | 120.0 | - | - | 1 | 120.0 | - | - | - | - | - | - |
| Орон нутгийн хөгжлийн сан | 2 | 70,000:0 | - | - | 2 | 70,000.0 | - | - | - | - | - | - |
| Хоршоо хөгжүүлэх сан | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| **Дүн** | **4** | **70,627.3** | - | - | **4** | **70,627.3** | - | - | - | - | - | - |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Засаг Даргын Тамгын Газар | 1 | - | - | - | 1 | - | - | - |
| Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 1 | - | - | - | 1 | - | - | - |
| Орон нутгийн хөгжлийн сан | 1 | - | - | - | 1 | - | - | - |
| **Дүн** | **3** | - | - | - | **3** | - | - | - |